



## МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 04 сарын 08

Дугаар 01

Улаанбаатар хот

“Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Гомбын Аюушмаа даргалж, хувьцаа эзэмшигч Г.Аюушмаа /эзэмшдэг хувьцааны тоо-524/, Б.Зориг /768062/, Д.Тунгалаг /97792/, Н.Дуламжав /15/, Би Ди Сек БДК /2497/-ийн төлөөлөгч О.Одбаяр /ЖЯ86081017/, Г.Ганзориг /ЧП80092612/ нар, С.Цэдэн-Иш /4/, Г.Эгшиглэн /1/, С.Мягмарсүрэн /123/, А.Чулуун /5/, хурлын тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуун нарыг оролцуулан “Материалимпэкс” ХК-ийн хурлын танхимд 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 10 цаг 40 минутад хийв.

/Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдээс Д.Үнэнзаяа, Д.Эрдэнэцэцэг, В.Ойдов, ердийн гишүүн Ч.Чинзориг, Т.Мөнхжаргал нар байлцсан болно/

Даргалагчаас: Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа, компанийн ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд, хууль болон бусад холбогдох журамд заасны дагуу 2014.02.09-нд хувьцаа эзэмшигчдийн хурлын товоо гаргаж, хурлын тооллогын комиссыг томилсон байгаа. Миний бие Г.Аюушмаа ТУЗ-ийн даргын албан тушаалыг эрхэлдэг тул компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасан эрхийн дагуу өнөөдрийн ХЭХ-ыг даргалан явуулах болно. Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг танилцуулъя. Дарга П.Баатарцэрэн нягтлан бодогч мэргэжилтэй, гишүүн Л.Нямдулам мөн нягтлан бодогч мэргэжилтэй, Д.Баатардорж инженер мэргэжилтэй. Эдгээр хүмүүс өнөөдрийн хурлын тооллогын комиссоор томилогдсон байна. Комиссын дарга, гишүүд ирцээ бүртгэж, мэдээллээ танилцуулна.

Нарийн бичгийн дарга: /Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч бүрийн итгэмжлэл, биеийн байцаалтыг шалгаж, тулгалт хийсэн ба Л.Нямдулам тэмдэглэл хөтөлснийг хавсаргав/. Ирцийн ажиллагаа 10 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга П.Баатарцэрэнгээс: Ирцийн мэдээллийг танилцуулъя. 2015.04.08-ны өдрийн 10 цаг 45 минутын байдлаар 1,368,206 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс 869023 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид ирсэн байна, ирц 63,5% байна гэв.

Даргалагчаас: Саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцох хууль зүйн үндэстэй байна. Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх
- Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах



## МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 04 сарын 08

Дугаар 01

Улаанбаатар хот

“Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Гомбын Аюушмаа даргалж, хувьцаа эзэмшигч Г.Аюушмаа /эзэмшдэг хувьцааны тоо-524/, Б.Зориг /768062/, Д.Тунгалаг /97792/, Н.Дуламжав /15/, Би Ди Сек БДК /2497/-ийн төлөөлөгч О.Одбаяр /ЖЯ86081017/, Г.Ганзориг /ЧП80092612/ нар, С.Цэдэн-Иш /4/, Г.Эгшиглэн /1/, С.Мягмарсүрэн /123/, А.Чулуун /5/, хурлын тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуун нарыг оролцуулан “Материалимпэкс” ХК-ийн хурлын танхимд 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 10 цаг 40 минутад хийв.

/Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдээс Д.Үнэнзаяа, Д.Эрдэнэцэцэг, В.Ойдов, ердийн гишүүн Ч.Чинзориг, Т.Мөнхжаргал нар байлцсан болно/

Даргалагчаас: Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа, компанийн ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд, хууль болон бусад холбогдох журамд заасны дагуу 2014.02.09-нд хувьцаа эзэмшигчдийн хурлын товоо гаргаж, хурлын тооллогын комиссыг томилсон байгаа. Миний бие Г.Аюушмаа ТУЗ-ийн даргын албан тушаалыг эрхэлдэг тул компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасан эрхийн дагуу өнөөдрийн ХЭХ-ыг даргалан явуулах болно. Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг танилцуулъя. Дарга П.Баатарцэрэн нягтлан бодогч мэргэжилтэй, гишүүн Л.Нямдулам мөн нягтлан бодогч мэргэжилтэй, Д.Баатардорж инженер мэргэжилтэй. Эдгээр хүмүүс өнөөдрийн хурлын тооллогын комиссоор томилогдсон байна. Комиссын дарга, гишүүд ирцээ бүртгэж, мэдээллээ танилцуулна.

Нарийн бичгийн дарга: /Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч бүрийн итгэмжлэл, биеийн байцаалтыг шалгаж, тулгалт хийсэн ба Л.Нямдулам тэмдэглэл хөтөлснийг хавсаргав/. Ирцийн ажиллагаа 10 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга П.Баатарцэрэнгээс: Ирцийн мэдээллийг танилцуулъя. 2015.04.08-ны өдрийн 10 цаг 45 минутын байдлаар 1,368,206 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс 869023 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид ирсэн байна, ирц 63,5% байна гэв.

Даргалагчаас: Саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцох хууль зүйн үндэстэй байна. Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх
- Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах

- Компанийн хөндлөнгийн Аудитын байгууллагыг томилох, түүнтэй гэрээ байгуулах этгээдийг томилох
- Ногдол ашиг хуваарилах тухай
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найрууллыг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэх болно.

Хурлын дараалал, дотоод журам /тэмдэглэлд хавсаргав/-ыг танилцуулаад Хэлэлцэх асуудлын дараалал болон бусад асуудлаар хувьцаа эзэмшигчдэд асуух болон хэлэх санал хүсэлт байна уу? Хурлын материалаас ТУЗ-ийн дүгнэлт, хэлэлцэх асуудал, дотоод журам, дүрэмд орсон өөрчлөлтүүдийг нэгбүрчилэн бичсэнийг тараасан ба хэт олон хуудастай бизнес төлөвлөгөө болон өмнөх оны тайланг хувилж тараах боломжгүй тул эх хувиараа бэлдсэн байгаа. Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлаас өмнө шаардлагатай материалтайгаа ирж танилцах бүрэн боломжтой байсан. Мөн хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг Хөрөнгийн бирж ба компанийн вэб сайтад байрлуулсныг олж үзсэн байх аа гэж найдаж байна. Өнөөдрийн хурлаа асуулт хариултын журмаар явуулах бөгөөд та бүхэн сонирхсон асуултаа тэмдэглэж байгаад минут харгалзахгүйгээр чөлөөтэй асууж болно.

Оролцогчид: Дараалал, хурлын материалтай танилцсан тул хэлэлцэх асуудалд оруулах саналгүй, асуулт хариултын журмаар явуулахыг дэмжиж байна гэгцгээв.

Даргалагчаас: Хурлын зарыг СЗХ-оос батлагдсан журмын дагуу явуулсан гэдгээ дурдъя. За ингээд асуух зүйл байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё. 2014 оны тайлант хугацааны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг аудитын хорооны дарга Д.Үнэнзаяагаас хэлэлцүүлнэ.

Д.Үнэнзаяагаас: Дүгнэлтийг уншиж танилцуулаад асууж тодруулах зүйл байгаа эсэхийг лавлав. /дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав/

Даргалагчаас: Дараалал ёсоор дараачийн хэлэлцэх асуудал нь 2015 оны бизнес төлөвлөгөөг гүйцэтгэх захирал Б.Зоригоос хэлэлцүүлнэ.

Б.Зоригоос: Төлөвлөгөөний хувьд хүн бүрт тараагдаагүй ч урьдчилан танилцах боломжоор бүрэн хангасныг хурлын дарга маань дурдсан. Төлөвлөгөөнөөс та бүхний сонирхож байгаа болов уу гэсэн орлого, зарлага, ашигийн асуудлыг өмнөх оныхтой харьцуулсан байдлаар слайдан дээр танилцуулахаар бэлдсэн байгаа. Болох уу?

Оролцогчид: Болно гэгцгээв.

Б.Зоригоос: Төлөвлөгөөг хуудас бүрээр слайдад бэлтгэсэн мэдээллээр танилцуулав. Үндсэн агуулгаасаа эхэлж, бизнес төлөвлөгөөгөө бид 2015 оны нэгдсэн төлөвлөгөө хэмжээн нэрлэсэн ба эхэнд нь компанийн танилцуулга, бүтэц зохион байгуулалт, эрхэм зорилгоо бичсэн байгаа. /бүтцийг тайлбарлав/ хувьцаат компани учраас ТУЗ-ийн 9 гишүүнтэй, үүнээс хараат бус гишүүн 3 бий бөгөөд өнөөдрийн хурал дээр хараат бус гишүүд болон бусад гишүүд маань урилгаар оролцож байгаа. Компанийн зорилго, зорилтоо шинэчилсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор ажиллагсадаасаа санал асуулга явуулж, цаашдын төлөвлөгөөндөө тусгах, ямар боломжийг ашиглах, анхаарах асуудлын хүрээнд SWOT шинжилгээ хийсэн байгаа. Үүндээ үндэслэж зорилтуудаа тодорхойллоо. Үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг бүтээгдэхүүн нэг бүрээрээ хийсэн ба 2014 оны арматурын гүйцэтгэлийн нэлээд нарийн гаргасныг та бүхэн харж байгаа байх. 2015 оны төлөвлөгөөнд үнийн дүн, тоотойгоо тусгасан нь гарч ирж байна. Дараагийн бүлэгт улс хоорондын тээвэр зуучлалын үйл ажиллагааны талаар тусгасан ба нэг цэгийн үйлчилгээний талаар оруулсан байна. Нэг цэгийн үйлчилгээ гэж оруулсан нь манай байгууллага бол энэхүү нэг цэгийн үйлчилгээг санаачлагч, анхдагч байгууллага тул тэр утгаараа оруулсан.

Мөн Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа, улс хоорондын тээвэр зуучлалын үйл ажиллагааг нэгбүрчилэн сар сараар нарийвчлан гаргасан ба 2014 оныхтой харьцуулсан байна. Дараа нь үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлтэс нэгж бүрээр гаргасан нь харагдаж байна, үүнээс нарийвчлан сонирхвол 2014 оны үйл ажиллагааны дүн 2015 оны төлөвлөгөөний дүн бол нарийвчлан суусан байгаа. Үүнээс манай хувьцаа эзэмшигчид маань илүүтэй сонирхох байх гэсэн асуудлын талаар төлөвлөгөөг ахалж хийсэн манай санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч П.Баатарцэрэнгээс дэлгэрүүлж танилцуулна гэв.

П.Баатарцэрэнгээс: Слайдан дээр 2013, 2014 оны зардлын гүйцэтгэл, 2015 оны төлөвлөгөөг тайлбарлав /тэмдэглэлд хавсаргав/.

С.Мягмарсүрэнгээс: Орлого буурсан хэрнээ ашиг өсөж байгаа нь ямар учиртай юм бэ?

П.Баатарцэрэнгээс: 4,2 тэрбум буюу өнгөрсөн оны нийт ашгаас өссөн дүнтэй байгаа. 1-рт, барилгын материалын худалдааны борлуулалт гээд энэ 32 тэрбумаар тодорхойлогдсон бол 2015 онд 25 тэрбум болсны гол орлогын нөлөө бол арматур дээр байгаа. Арматурын маань үйл ажиллагаа нь хэрхэн явагддаг вэ гэхээр энэ ондоо арматураа татан оруулж ирдэг ба 8-32 хүртэл диаметрийн хэмжээнээс хамаарч олон төрөл байдаг гэсэн үг юм. Оруулж ирдэг нь бүдүүн хэмжээнийх байдаг ба худалдан авагч нар маань аль алианаас нь авдаг тул худалдан авагчийхаа захиалгыг аль болох бүрэн хангахын тулд бараа солилцоо ижил төрлийн бизнес эрхлэгч нартайгаа хийдэг. Өөрөөр хэлбэл бүдүүн замын арматураар нарийнийг солих солилцоо хийдэг, та бүхэн мэдэж байгаа бол манай дотоодын төмөрлөгийн үйлдвэрүүд нарийн хэмжээтэйг ихэвчлэн үйлдвэрлэдэг. Энэ 32 тэрбум дотор манай өөрийн оруулж ирсэн арматур дээр солилцоогоор орж ирж байгаа арматурын борлуулалт нэмэгдэж орж ирж байсан бол 2015 оны төлөвлөгөөндөө цэвэр өөрийн импортоор оруулж ирэх бүтээгдэхүүний борлуулалтаа тавьсан, бараа солилцоог оруулаагүй гэсэн үг. Солилцооны бүртгэл нь бараа материал дээрээ хүлээн зөвшөөрч бүртгээд нөгөө талдаа буюу зарлага талдаа бүртгэж явдаг тул орлого, зарлага 2-ыг зэрэг өсгөж байдаг. Солилцооны бараанд ашиг нэмэгддэггүй юм. 25 тэрбум нь цэвэр манай импортоор оруулж ирээд ашиг тооцсон үзүүлэлт юм. 2-рт, мэдээж ашиг олохын тулд тухайн барааны үнийн дүнг үндсэн барааны үнээ 1 сая төгрөгөөр тооцсон. Энэ үнэ нь одоогийн 4 сард зах зээлд борлогдож байгаа үнэ ба энэ үнийг удирдлага болгон ашгаа тооцсон, жилийн дундуур өсөх магадлалтай прогноз бий хэдий ч эхэн үеийнхээ ханшаар тооцсон байдал юм гэв.

Б.Зоригоос: 2014 онд татан авалт хийсэн бодит дүн бол 20,000 тонн бөгөөд тайланд 28,000-аар тусгагдсан. Өөрөөр хэлбэл 8000 тоннын солилцоо хийсэн гэж ойлгож болно. 2015 онд 25,000 гэдэгт солилцооны дүн ороогүй, хэдийгээр барилгын салбар хүндхэн, улс орны эдийн засаг сайнгүй байгаа ч бид төлөвлөхдөө өнгөрсөн оноос бууруулах ёсгүй гэж үзсэн юм. Гүйцэтгэл санал 2 дээр буурсан харагдаж байгаа ч бодит байдал дээр 2015 оны бодит борлуулалт ийм байх болов уу гэж харж байгаа юм.

Н.Дуламжаваас: Татан авалт зэргийг үнэхээрийн сайн ойлгохгүй байна. нийт орлого урд жилээс буурсан хэрнээ ашиг юунаас 1 тэрбум орчим буюу 900 сая гарангаар нэмэгдээд байна вэ?

П.Баатарцэрэнгээс: Сая тодорхой тайлбарлалаа шүү дээ, энгийнээр тайлбарлахад компанийн нийт зардал маань 44 тэрбумаас энэ онд 35 тэрбум болж буурч орж ирж байгаа, гол нөлөөлөл нь арматурын татан авах гэрээний үнэ энэ жилийн хувьд буурсантай холбоотой. Тэгэхээр ашиг нэмэгдэж байгаа юм гэв.

С.Цэдэн-Ишээс: Дандаа Хятадаас авдаг уу?

П.Баатарцэрэнгээс: БНХАУ-ын Бугатын улсын төмөрлөгийн үйлдвэртэй гэрээтэй ажилладаг гэв.

Б.Зоригоос: Бараа солилцоо хийдэг учраас Дарханых ч байдаг, ОХУ-ынх ч бий гэв.

П.Баатарцэрэнгээс: Солилцоо гэдгийг жоохон тайлбарлавал манайх бүх размерийн буюу 13 төрлийн хэмжээ байдгийг бүгдий нь оруулж ирэх эргэлтийн хөрөнгийн боломж компанийн хувьд хязгаарлагдмал байдагтай холбоотой юм гэв.

Н.Дуламжаваас: Тэр нарийн зүйлсийг бид мэдэх шаардлагагүй дээ гэв.

Б.Зоригоос: Зардалд буурсанд нөлөөлсөн гол хүчин зүйл нь манай урд хөршийн эдийн засгийн байдлаас шалтгаалж үнэ буусан, шууд утгаараа тэгж л ойлгож болно. Бид төлөвлөхдөө өмнөх жилээс өртөг буурсан ч аль болох л боломжийн үнээр борлуулахыг эрмэлзэнэ шүү дээ гэв.

Н.Дуламжаваас: Ойлголоо. Ноднингийн тайлангаас асууя, балансаас харсан юм л даа, ноднин нийт хөрөнгийн дүн 6 тэрбум 259 саяар буурсан, цэвэр ашиг 2013 оныхоосоо 583 саяар нэмэгдсэн харагдаж байсан нь бидний хувьд их баяртай тоо л доо. Борлуулалтаас 5 тэрбум 774 сая нэмэгдэж, өр 8 тэрбумаар буурсан нь хувцгаа эзэмшигч бидний хувьд баяртайгаар хүлээж авах гоё тоо учраас өнөөдөр энэ хуралдаа ирэхдээ баяр тэмдэглэх гэж байгаа мэт сэтгэгдэлтэй ирлээ. Амжилттай сайхан ажилласан байна, 2014 он ямар байсныг бид бүхэн мэдэж байгаа, тийм байхад ийм их хэмжээний ашигтай ажиллаж, борлуулалтаа өсгөөд явна гэдэг бол манай компани сайн байгаагийн шинж юм гэв.

С.Цэдэн-Ишээс: САйхан орлоготой сайхан ажилласан байна гэв.

Даргалагчаас: Н.Дуламжав хувьцаа эзэмшигчийн асуултад санхүүгийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч Л.Нямдуламаас хариулъя.

Н.Дуламжаваас: Би санхүүгийн талын хүн биш учраас ойлгохын тулд асууж байгаа юм шүү, яагаад нийт хөрөнгө буурсан юм бэ?

Л.Нямдуламаас: Ерөнхийдөө дансны авлага байгаа. Манай компани 18 тэрбум төгрөгийн дансны авлагатай байсан бол авлагаа барагдуулж 11,9 тэрбум хүртэл бууруулсан юм. Иймд гол нь авлага буурсантай холбоотой, бараа материал мөн 1 тэрбум орчим төгрөгөөр буурсан. Бараа материал буурна гэдэг маань бараагаа зарсан л гэсэн үг шүү дээ гэв.

Н.Дуламжаваас: Өр 8 тэрбум гарангаар буурна гэдэг бол их сайн үзүүлэлт л дээ гэв.

П.Баатарцэрэнгээс: 2014 оны зорилт маань авлагаа барагдуулж эргэлтийн хөрөнгөө сайжруулах байсан гэв.

Н.Дуламжаваас: Сүүлийн асуулт байна, бид хөрөнгийн бирж дээрх тайлан баланс хардаг, түүн дээр нэгж хувцьяанд ногдох ногдол ашиг 2000 хэдэн зуун төгрөг гэж гарсан байсан, ноднингийн тайлангаар энэ жил 80 төгрөгийн ногдол ашиг өгсөн л дөө. 2000 давсан ногдол ашиг байсаар байтал бидэнд яагаад ийм жоохон өгөөд байна вэ гэж л асуумаар байна? энэ тоогоо ахиулах боломж байдаг юм болов уу? Баянгол бас 300 төгрөгийн л ногдол ашиг өгдөг, үйлдвэрлэл үйлчилгээнд чухал нөлөөтэйг ойлгож байгаа хэдий ч асуумаар санагдаад байдаг юм. Хувьцааны үнэлгээ энэ жил бас их сайн байсан л даа, хамгийн дээд тал нь 19,000 хүрсэн, одоо бол 15,000 төгрөг байна. энэ юуг үзүүлээд байна вэ гэхээр хүмүүсийн сонирхол манай ашгийг мэдэж байгаа, хувьцааны үнэлгээ өсөх хандлагатай байгаа учраас асуугаад байгаа юм шүү гэв.

Б.Зоригоос: 2013 онд 100 төгрөг, 2014 онд 80 төгрөгийн ногдол ашгийг нэгж хувьцаа бүрт олгосон. Компани хэдийгээр ашигтай ажиллаа гээд бүгдий нь ногдол ашиг болгон тараагаад байвал яаж өргөжин тэлэх вэ дээ тийм үү? Бид үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт хийж байгаа үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй л дээ. Манай хурлын

дараачийн асуудал бол ногдол ашгийн талаар байгаа хэдий ч би нэгэн зүйл тайлбар болгоод хэлчих үү?

Даргалагчаас: Болно.

Б.Зоригоос: Нэгэнт асуусан юм чинь ярьчихъя. Сая жишээ хэлж байна л даа, Баянгол 6300 хэрнээ түүнээсээ 300 төгрөгийн ногдол ашиг өгдөг гээд, үүнийг хувилаад бодоод үзэхэд 5% байна л даа. Ер нь бол жижиш бол 3-5 орчим хувийг ногдол ашиг болгон хуваарилдаг. Манайх дээхнэ үед олон жил ашиггүй ажиллаж байгаад 2010, 2011 оноос ашигтай ажиллаж эхлэхдээ ногдол ашгийн хэмжээний талаар судалж байсан. Тухайн үед бид ТУЗ дээрээ ч ярьж л байсан, юу гэж судалсан бэ гэхээр 3-5%-ийн ногдол ашиг хуваарилж байа гэсэн. 2012 оны 100 төгрөг бол 5%, яг нарийн хэлж мэдэхгүй, 2013 оны 80 төгрөг бол 4.6 орчим хувь. Одоо 2014 онд яригдаж байгаа, оруулж байгаа саналын хэмжээ бол 80 төгрөг нь 4 гаран хувь юм. 2-рт бид, бид ч юу байхав бүх л компаниуд ийм бодлого баримталдаг, олсон ашгаа жил бүр өгөөд байвал яаж бид өргөжих билээ. Бид өргөжиж л байвал хувьцааны үнэ цэнэ өсөж байна гэж ойлгоорой гэж хүсэх байна. Бирж дээр манай хувьцаа 15000-15500 орчим дээр тогтож байх шиг харагддаг. Би ч өөрөө хувьцаа эзэмшигчийн хувьд 15000 төгрөг бол манай хувьцааны бодит үнэ юм байна гэж ойлгодог. Энэ жил бид арай илүү хуваарилах талаар ярилцсан л даа, гэхдээ та бүхэн энэ жил манай улс орны эдийн засаг, тэр дундаа барилгын салбар ямар байгаа билээ, тэр байтугай 2017 оны гэхэд энэ байдал сэхэх үү үгүй юу гэдэг бол эргэлзээтэй, өнөөдрөөс харахад гэрэл гэгээ харагдахгүй байна. Гадны хөрөнгө оруулалт орж ирнэ гэж Засгийн газраас яриад байгаа боловч яг ороод ирчихсэн зүйл алга л байна, тийм учраас бид компанийхаа энэ жилийн, дараа жилийн үйл ажиллагаанд бас тодорхой хэмжээгээр хөрөнгө байх хэрэгтэй гэж хандсан юм шүү гэв.

Н.Дуламжаваас: Дансны үнэ бол яг 6600 байдаг юм билээ гэв.

С.Цэдэн-Ишээс: Материалимпэкс маань 100% хувийн компани уу, төрийн оролцоо байдаг уу?

Даргалагчаас: Хувийн хувьцаат 1635 хувьцаа эзэмшигчтэй.

Б.Зоригоос: 70 гаруй хувь нь над дээр төвлөрсөн байдаг гэв.

Даргалагчаас: Хэлэлцсэн асуудалтай холбоотойгоор өөр асууж тодруулах зүйл, санал хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэцгээв.

Даргалагчаас: Дараагийн хэлэлцэх асуудал ногдол ашгийн хуваарилалтын талаар манай аудитын хорооны гишүүн танилцуулах байсан. Гэхдээ бараг яригдчихлаа даа. Мэдээллийг сонох уу?

Оролцогчид: Шаардлагагүй ээ, бид ойлгосон гэв.

С.Мягмарсүрэнгээс: Энэ эрсдлийн сан гэж байна. Энэ ямар зорилготой юм бэ, хот төлөвлөлт маань бас өөр маягаар явагдах гээд байх шиг байна, ялангуяа энэ тээвэр зуучлалын үйл ажиллагааг хотоос гаргана, Багахангайд байрлуулна энэ тэр гэж байх шиг байна. Тэр талаар ер нь ямар бодолтой байна вэ?

Б.Зоригоос: Яг энэ асуудлуудыг бид тооцож үзсэн. Тээвэр зуучийн хувьд нэгтгээд Богд уулын хажуугаар төмөр зам явж байгаатай холбоотойгоор нэгдсэн терминалуудыг 2 газар байгуулъя гэж шийдсэн байдаг, энэ талаар олон жил ярьж байна. Яг Хөшигтийн хөндийн шинэ онгоцны буудалд нэг нь, нөгөө нь Гацууртын цаад талын Хоолт билүү дээ өртөөн дээр гэж яригдаж байсан. Монголын үндэсний Тээвэр Зуучдын Холбооноос санаачлага гарган Хоолт дээр бид 141 билүү 147 тээвэр зуучийн байгууллагууд нэгдэж, эдгээр үйл ажиллагаа явуулдаг компаниудынхаа эрх ашгийг харгалзан үзээд тэнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулаад Хоолт дээр нэгдсэн үйл ажиллагаа явуулъя гэсэн санаачлага гаргаад одоогоор 2, 3 жил ч болж байна уу даа.

Улаанбаатар нэгдсэн ложистик төв гэж байгуулсан, тэрэнд нь орсон тээвэр зуучийн компаниуд ч бий, ороогүй нь ч байгаа. Манай хувьд түүнд нь тодорхой хувь эзэмшээд орсон, тэнд үйл ажиллагаа эхлэхийн тулд нэлээдгүй хэмжээний хөрөнгө оруулна, Улаанбаатар нэгдсэн ложистик төв Компанийг байгуулахад үүсгэн байгуулагчаар орсон юм чинь дүрмийн санд хөрөнгө хийж таарна, тэр тоо бол анхны тоонууд нэлээд том тоонууд явж байгаа, бид эдгээрийг бодож үзээд эрсдлийн сангаа эртнээс байгуулж, аль болох ахиухан хөрөнгө төвлөрүүлэх бодлого баримталж байна. 2-рт, хот төлөвлөлттэй холбоотойгоор манай энэ эзэмшил газар дээгүүр төв зам явна ч гэх шиг зүйл яригдаж байгаа ч эцсийн байдлаар одоохондоо шийдсэн зүйл алга байна. баянгол дүүргийн нутаг дэвсгэр дээр хийсэн байсанд би тодорхой хэмжээгээр саналаа өгчихсөн байгаа, тэрэнтэй холбоотойгоор шилжилт хөдөлгөөн гарахыг үгүйсгэхгүй. Байг гэхэд энд олон том жижиг байгууламжууд байдаг, жишээ нь эрчим хүчээр баруун бүсийг хангах байр байшин олдохгүй байна гээд манай газар дээр барьчихсан байгаа, үүнтэй холбоотой маш их бэрхшээл үүсч байсан, тэр том том 35, 45-ын шугамууд явах газар байхгүй гээд дандаа манай хашаан дундуур явуулдаг зэрэг хүндрэлүүд байна. дээрээс нь орон сууцжуулах, барилгажуулалттай холбоотойгоор зам талбай, хашаа хорооны битүүмжлэл яригдажна. Ноднингийн ХЭХ дээр ч яригдаж л байсан, ийш тийшээ задгайг, хулгай ихтэй зэрэг, үүнтэй холбоотойгоор битүүмжлэл, зам талбайн тохижилт хийхэд анхаарах шаардлагатай болж байгаа юм. Үүнд бас эрсдлийн сан хэрэгтэй гэсэн бодолтойгоор ажиллаж байгаа юм гэв.

А.Чулуунаас: Ногдол ашгийг дансаар тараадаг, гэтэл зарим хувьцаа эзэмшигч маань үхчихсэн ч байдаг юм уу, хөдөө малчин ч байдаг юм уу, хувьцаатай эсэхээ ч мэдэхгүй хүн байдаг. Үнэт цаасны газар чинь бараг 2 тэрбумаар төгрөг байж л байдаг, авах хүн нь байдаггүй гэж сонсож байсан, үүн дээр анхаарч, компани дээрээсээ авдаг болгодог юм уу яадаг юм анхаарах хэрэгтэй юм шиг санагддаг юм гэв.

Даргалагчаас: Манай компани нь "ҮЦТТТХТ" ХХК-тай жил бүр гэрээтэй ажиллаж, энэ компаниар дамжуулан ногдол ашгаа хуваарилдаг байгаа. Үүнийг хувьцаа эзэмшигч нэг бүрийн гар дээр очих асуудлыг брокер дилерийн пүүсүүд дамжуулах ёстой байдаг журмын дагуу, гэрээнийхээ дагуу ногдол ашгаа хуваарилж байгаа юм.

С.Цэдэн-Ишээс: Ногдол ашгийг хэд хоногт тараадаг юм бэ?

Даргалагчаас: Ногдол ашгийн хэмжээ тогтоосон ТУЗ-ийн шийдвэр гарахдаа хугацааг заасан байдаг, гэрээг бид ихэвчлэн тухайн тайлант хугацаандаа багтааж буюу жил бүрийн 12 сарын 31-ний дотор гэж заасан байдаг юм.

Б.Зоригоос: "ҮЦТТТХТ" ХХК-тай гэрээ байгуулаад тэдний дансанд ногдол ашгаа тооцоод, шимтгэл хураамжаа төлөөд шилжүүлдэг. Авч чадахгүй хүмүүсийг яах ёстойг мэдэхгүй байна, зарим зайлшгүй тохиолдолд манайх компаниасаа ногдол ашгаа тараадаг. Ер нь бол дансгүй хүн хувьцаатай байна гэж одоо байхгүй болсон байх гэж ойлгодог гэв.

Н.Дуламжаваас: Газар сүлжмэл л лав компани дээрээсээ ногдол ашгаа тараагаад авахгүй хүмүүсийхээ мөнгийг компани дээрээ байлгаж эргэлдүүлж байх нь ашигтай гэдэг юм байна билээ. Тэгж болдог юм шиг байна гэв.

Б.Зоригоос: Тийм байгууллага байж болно оо, манай хувьд эрх бүхий байгууллага гэж байна, тэгээд ч 1600 гаруй хувьцаа эзэмшигчид шүү дээ. Нэгэнтээ манайхыг төлөөлөөд гэрээ хийсэн компани байхад бид тэрүүгээрээ л дамжуулах нь зүйтэй юм уу гэж боддог юм. Яаж тараах журамтай юм тэрүүгээрээ л болно доо гэв.

Н.Дуламжаваас: Одоо тэр кастедион банк нь ороод ирчихвэл энэ асуудал арай өөр болох байх л даа гэв.

С.Мягмарсүрэнгээс: Тээвэр зуучийн үйл ажиллагаа явуулдаг хэр олон компани байдаг юм бол? Нэг ёсондоо өрсөлдөгч хэр олон байдаг вэ?

Б.Зоригоос: 141 билүү 147 компани бүртгэлтэй, эрхтэй байдаг гэсэн мэдээлэлтэй байна. Гэхдээ миний ойлгож байгаагаар бодит үйл ажиллагаа явуулж байгаа нь 40 гаруй байх шиг байгаа юм, яг өөрийн гэсэн терминаль, гаалийн бүстэй 9 компани байдаг юм шиг байна лээ. Техник хангамж, талбайн хэмжээ болон бусад бүх талаараа манайх ер нь бол гайгүй сайн л гэж боддог. Тэр утгаараа манай тээвэр зуучийн үйл ажиллагаа харьцангуй сайн явдаг юм болов уу гэж ойлгодог. Албан ёсны дүн биш ч гааль болон төмөр зам дээр гарч байгаа дүн мэдээллээс харахад ачаа эргэлтийн тоогоороо жил бүр 2 юм уу 3-т жагсаад байдаг юм. Үүнээсээ харьцангуй гайгүй юм болов уу гэсэн ойлголтыг авдаг гэв.

С.Цэдэн-Ишээс: Салбар, охин компани байдаг уу?

Б.Зоригоос: Үндсэндээ 2 байдаг гэж ойлгож болно, хэдийгээр статусын хувьд ХХК гэж явдаг боловч манай компанийн үндэс суурин дээр үйл ажиллагааг явуулдаг "Материалимпекс констракшн" ХХК, "Монголиан Степ тур" ХХК гэж бий. Гэхдээ тайлан тооцоогоо тус тусдаа гаргаж явдаг, нэгтгэгддэггүй ч манай үйл ажиллагааны тайлан төлөвлөгөөнд орсон байдаг юм гэв.

Даргалагчаас: Дараагийн асуудалдаа орох уу?

Оролцогчид: Тэгье гэв.

Даргалагчаас: Компанийн хөндлөнгийн аудит хийх байгууллагыг томилох, түүнтэй гэрээ хийх эрхийг олгох тухай асуудал байна. ТУЗ-ийн аудитын хорооноос байгууллагын талаар танилцуулъя.

Д.Эрдэнэцэцэгээс: За манай компани өмнө нь "Далайван аудит" ХХК-иар аудит хийлгэж байсан. Гэвч СЗХ болон бусад эрх бүхий байгууллагаас нэг байгууллагаар олон жил аудит хийлгэх нь зүйтэй биш зүйл гэж үздэг учраас энэ жил манай аудитын хороо ярилцаад аудитын байгууллага солихоор шийдэж судалгаа хийлээ. Бид хамгийн йх анхаарсан зүйл бол аудит хийхэд энэ компанид байгаа эрх бүхий болон бусад ажилтан албан тушаалтнуудтай харилцаа хамааралтай эсэхийг судлах нь чухал байлаа. Манай компани чамгүй олон тооны ажиллагсадтай тул хөндлөнгийн аудит хийхэд нөлөөллөөс зайлсхийх нь нэн чухал асуудлын хувьд чухалчлан судлан үзсэн гэдгийг хэлмээр байна. Өнөөдөр та бүхэнд танилцуулах компанийн хувьд дээрх бүхий л шалгууруудыг сайтар судалсны эцэст сонгосон юм шүү. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал маань санхүүгийн жил дууссанаас хойш улирал илүүгийн хугацаанд хийгддэг, энэ хуралдаа орж ирэхдээ бид санхүү, үйл ажиллагаандаа аудит хийлгэсэн байх ёстой журмынхаа дагуу хийсэн учраас нэг л компанийг танилцуулж байгаа юм. Дараа дараагийн хуралдаа урьдчилан бэлтгэж, олон сонголттойгоор танилцуулах болно. Өнөөдрийн бас нэг компани танилцуулж байгаа шалтгаан нь манай ТУЗ нь өмнөх жилийн ХЭХ-аар сонгогдож бүрэн эрх нь баталгаажсан ба шинэ бүрэлдэхүүнээрээ энэ жилийн тайлант хугацаанаас эхлэн аудитын байгууллагыг солих нь зөв гэж дүгнэсэн гэдгээ тайлбарлах нь зөв. Ингээд бид "Мишээл Од Аудит" ХХК-ийг үйлчлүүлэхээр сонгосноо танилцуулж байгаа бөгөөд хувьцаа эзэмшигч та бүхний саналыг сонсож, дараа дараагийн жилдээ анхаарч ажиллах болно гэв.

Н.Дуламжаваас: Та бүхэн сайн судалсан л байна шүү дээ. Зөв шүү дээ, би хувьдаа дэмжиж байгаагаа шууд хэлмээр байна гэв.

Бусад оролцогчидоос: Дэмжиж байна, асуух зүйл алга байна гэв.

Даргалагчаас: Аудитын байгууллагын талаар нэмэлт тайлбар, тодруулга, шаардлагатай зүйлсээ сайн асууж лавлаарай хөрөнгө оруулагч нараа?

Оролцогчид: Асуух зүйлгүй гэв.



Даргалагчаас: Аудитын хийх байгууллагаар “Мишээл Од Аудит” ХХК-ийг сонгох эсэх талаараа гишүүд маань саналын хуудсаараа саналаа өгөх байх. Харин аудитын байгууллагатай гэрээ хийх эрхийг ТУЗ-дөө олгох нь зүйтэй юу?

Оролцогчид: Тэр мэдээжийн хэрэг шүү дээ гэв.

Даргалагчаас: За хэлэлцэж байгааг асуудлуудын талаархи саналаа та бүхэн тэмдэглэж байгаа гэж найдаж байна, тодорхойгүй, ойлгомжгүй, эргэлзээтэй зүйл байвал асууж тодруулаарай.

С.Мягмарсүрэнгээс: За тайлан болон төлөвлөгөө гээд хэлэлцэж байгаа асуудлуудын талаар тодорхой мэдээлэл авч чадлаа. Сонирхож асуух зүйл байна, борлуулалтын орлогын ихэнхийг арматур эзэлдэг юм байна, нөгөө бусдыг нь юуны орлогоос бүрдүүлдэг юм бэ?

Даргалагчаас: Орлогын дарааллаар асууж байгаа тул санхүүгээс хариулъя.

П.Баатарцэрэнгээс: Арматур 50%, бетон зуурмаг, тээвэр зуучлал 2 нийлээд 40% орчим, үлдсэн нь 10% байдаг гэв.

Даргалагчаас: За дараагийн хэлэлцэх асуудалдаа орох уу? Завсарлага авах уу, хурал эхлээд 2 цаг болоогүй ч та бүхний саналыг сонсьё.

Оролцогчид: Завсарлага авахгүй, хурлаа үргэлжлүүлье гэв.

Даргалагчаас: Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах асуудал байгаа. Дүрмийн хувьд Компанийн тухай хууль шинэчлэгдлээ, Үнэт цаасны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орж, шинэчлэгдсэнтэй холбоотойгоор, мөн манай компани үйл ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд зарчмын хэд хэдэн зүйл заалтад өөрчлөлт орж байгаа, мөн хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загварт нийцүүлэх зэрэг цаг үеийн шаардлагаар тодорхой хэдэн зүйл хэсэгт өөрчлөлт орсныг та бүхэнд урьдчилан танилцуулсан байгаа. Хуучин дүрмээс 55 орчим зүйлд өөрчлөлт орж, 1 бүлэг шинээр нэмж, 3 зүйлийг бүр хасаж, 15 бүлэг 350 гаран зүйлтэй дүрмийг шинэчлэн найруулсныг та бүхэнд танилцуулж, хэлэлцүүлж байна. Та бүхэн орсон өөрчлөлтүүдийн үг үсэг, утга найруулга ямар байсныг хэрхэн өөрчилсөн, аль зүйл заалтад юу гэж байсныг хассан, нэмсэн зэргийг нэгбүрчилэн тайлагнаж бичсэнтэй танилцлаа. Энэ өөрчлөлтүүдэд хөрөнгө оруулагчийн, хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хөндөж дордуулсан зүйл заалт нэг ч байхгүй гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэж байна. Та бүхэн уншиж танилцсан дүрмийн өөрчлөлтөөс асууж тодруулах зүйл байвал сайтар асууж тайлбар авахыг хүсье.

Шинээр нэмэгдсэн тэр өргөх байгууламжтай холбоотой 3.4.4 дэх заалт бол лифт юм шүү, нэр томъёоны хувьд стандартад нэрлэснээр бичсэн байгаа, мөн энгийн нийт зарласан хувьцааны тоог 10 сая ширхэг, үүнээс давуу эрхийн хувьцааны тоог 5 сая гэсэн саналыг оруулсан байгаа шүү. Гаргасан хувьцааны тоо, нэрлэсэн үнэ зэрэг өөрчлөгдөөгүй гэдгийг тодруулж хэлье.

А.Чулуунаас: Дүрмийн хувьд уншиж танилцлаа, өөрчлөлтүүдийг ч харлаа. Мэдээж хууль, журамд нийцсэн л байгаа гэдэгт итгэлтэй байгаа тул яриад байх юм алга байна гэв.

Даргалагчаас: Дүрмийн өөрчлөлтөөс асууж тодруулах зүйл байна уу? Асуултад хариулахад манай дүрмийн өөрчлөлтийг шинэчлэн найруулсан ажлын хэсэг бүрэлдэхүүнээрээ байгаа шүү.

Оролцогчид: Асуух зүйл алга байна, шинэчилсэн дүрмээ баталъя гэв.

Даргалагчаас: Хэлэлцсэн асуудлуудын хүрээнд асуух, тодруулах зүйл байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Асуулт, хариултыг бол хэлэлцсэн асуудал тухай бүрт явууллаа гэж ойлголоо. Санал, шүүмжлэл, зөвлөх зүйл юу байна вэ?

С.Мягмарсүрэнгээс: Материалимпэкс ХК-д нийт хэдэн хүн ажиллаж байна вэ?

Б.Зоригоос: яг Материалимпэкс гэвэл 89 байна, бүгд нийлээд 134 орчим бий гэв.

С.Цэдэн-Ишээс: Дандаа залуучууд уу?

Даргалагчаас: Хөгшин залуу гээд бүх үеийн төлөөлөл байна.

С.Мягмарсүрэнгээс: Цангийн дундаж хэд байдаг вэ?

Ерөнхий нягтлан бодогч Л.Нямдуламаас: Зарим хүмүүс хийснээрээ, ээлжийн харуулууд гараагаараа, бусад нь тогтмол, илүү цагийн гээд янз бүр байдаг. Ерөнхийд нь дундажлаад үзвэл 700,000 гарантай байдаг гэв.

Б.Зоригоос: Ажлын ачаалал ихтэй үед бол манай зарим кранчид 3 сая гаргаад авах үе ч бий гэв.

С.Мягмарсүрэнгээс: Захиргаа удирдлагад хэчнээн хүн ажилладаг вэ?

Б.Зоригоос: 30 гаран байна гэв.

А.Чулуунаас: Ер нь ингээд хараад байхад аль ч компанид газрын маргаан энэ тэр гээд их байх юм. Энэ компанид ч байгаа гэж дуулж байлаа, их том сургамж болж байгаа байх гэж найдаж байдаг, одоо хууль ёс нь аль нам гарав, ерөнхийлөгч шударга байна уу үгүй юу гэдгээс их шалтгаалж байх шиг байгаад болгоомжтой хандахгүй бол болохгүй харагддаг. Танайх ер нь эрсдэл гэж ярихгүй байна, эрсдэл гайгүй юм шиг байна л даа, жишээ нь аваар осол гарлаа, хоолондоо хордлоо ч гэдэг юм уу тийм зүйл Материалимпэксийн хувьд дуулддаггүй нь их сайшаалтай юм.

Даргалагчаас: Эрсдэл бол гайгүй, газрын маргааны асуудал ноднингийн хурал дээр нэлээн яригдсан, одоо газартай холбоотой маргаан байхгүй гэж ойлгож болно. Харин шүүхээс гарсан шийдвэрийг биелүүлэхтэй холбогдсон асуудлууд дээр маргаантай зүйл байгаа. Та бүхэн сонин хэвлэлээр уншиж байгаа байх, ТУЗ болон миний зүгээс дагнасан шүүхийн мэргэшсэн шүүгчид хэр зэрэг мэргэжлийн шийдвэр гаргаж чадаж байна вэ гэж, дараа нь хууль хяналтын байгууллагын дарга нарыг урьж байна гэж нэг бичсэн, саяхан ШЕЗ-ийн дарга н.Лүндээжанцанд ил захидал бичсэн байгаа. Шүүх, прокурорын байгууллагууд хурдан шуурхай ажиллахгүй байгаатай холбогдуулаад манай үйл ажиллагаанд ялихгүй бага бага хүндрэл байдаг. Эдгээр нь зүгээр болно гэж найдаж байдаг, шүүхийн шийдвэр нь байгаа юм чинь. Бид компанийхаа нэр хүндийг бодож ажиллах ёстой, манай компани бол монголдоо төдийгүй олон улсдаа танигдаж яваа компани шүү дээ, хамгийн гол сайн байх хөшүүрэг бол компанийн нэр хүнд сайн байх явдал гэж бид ойлгодог учраас аядуу зөөлөн, хуулийн дагуу, хийдэг ёстой ажлыг нь хийх ёстой хүнээр нь хийлгэх гэж цаг алдаж маргаад байгаа юм. Энэ тал дээр манайхан зөв ойлгоорой.

Эрсдлийг бол байг гэх аргагүй, шууд үгүйсгэх боломжгүй зүйл л дээ. Гадна орчны нөлөөллөөс гарч ирдэг зүйл, гал түймэр, үер ус байгаль цаг уурын, хулгайн гэх мэт эрсдлүүд гарахыг үгүйсгэхгүй. Тийм ч учраас эрсдлийн сан гэдгийг байгуулж тодорхой хэмжээгээр хөрөнгө хуримтлуулж байгаа тухай түрүүн яригдсан байгаа.

Б.Зоригоос: манайх ХАБЭАХэлтэстэй, 4 хүн ажилладаг, эдгээр хүмүүс маань маг боломжийн ажилладаг гэж боддог, яг үнэндээ гаалийн хяналтын бүс, барилгажилтын талбай зэрэг нь аюлтай бүс шүү дээ, галт тэрэгний сэлгээ 24 цагаар хийгдэж байна, вагон тавьж байна, татаж байна, орж байна, дээрээс нь том кранууд ажиллаж байна, доор нь үйлчилгээ явуулж том тэрэгнүүд чингэлэг ачиж буулгах, ачаа бараа буух зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлж байдаг. Эдгээр нь аюултай бүсэд тооцогддог, бид заримдаа ачаалал ихтэй үедээ 24 цагийн горимоор ажилладаг, мууг зөгнөөд яах вэ, маш анхаарал болгоомжтой ажиллахыг эрмэлздэг юм гэв.

С.Цэдэн-Ишээс: Ажилчдаа сургадаг, эмнэлэгт үзүүлдэг барьдаг зүйл байдаг уу?

Даргалагчаас: Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар бид жилдээ нэг удаа үнэ төлбөргүйгээр бүх ажиллагсадаа эрүүл мэндийг цогц үзлэгт хамруулж мэргэжлийн

байгууллагаар дүгнэлт гаргуулдаг. Жишээ нь манай энэ жилийн ээлжит үзлэг 2015.04.15-ны өдрөөс болно, нэг хүний үзлэгийн зардал болох 52,000 төгрөгийг компани хариуцаж төлдөг. Цаашлаад оосорлогч, дохиочин, авто ачигчийн жолооч, мэргэжлийн зэрэг ахиулах зэргээр жилдээ 10-аас доошгүй хүнийг сургаж, давтан сургалтад хамруулж, мэргэжил эзэмшүүлдэг, мөн жил бүр 10 гаруй хүнийг гадаад улсад компанийн зардлаар амраах, өвөлдөө цасны баяр, зундаа явган аялал, 7 хоног бүр заал авах гэх мэтийн ажиллагсадад хандсан алжаал тайлах үйл ажиллагаанууд тогтмол явагддаг юм.

Оролцогчидоос: Өөр хэлж ярих санал, шүүмжлэл, зөвлөх зүйл алга байна гэв.

Даргалагчаас: Тооллогын комисс саналын хуудсаа тараая.

/Тооллогын комиссын гишүүд санал авах хуудас тарааж бөглөх журмыг тайлбарлан өгөв.

Тооллогын комиссын гишүүд санал авах хуудсыг хураан авч саналын хуудсаа тоолов/

Тооллогын комиссын дарга П.Баатарцэрэнгээс: Тооллогын дүнгийн тухай комиссын тогтоол уншиж танилцуулав. Утга нь:

1. Тооллогын комисс 9 ширхэг санал авах хуудсыг нээж шалгахад 9 саналын хуулас гарснаас 9 хуудсыг хүчинтэйд тооцож,
2. Хүчинтэйд тооцсон саналын хуудаснаас хэлэлцсэн дараах асуудлуудыг доорхи хувиар баталсныг тогтоож, үүнд:
  - Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, ТУЗ-ийн дүгнэлтийг 100%,
  - Аудитын хорооны дүгнэлтийг баталсан 100%,
  - 2015 оны бизнес төлөвлөгөөг баталсан 100%,
  - Компанийн хөндлөнгийн Аудит хийх байгууллага, түүнтэй гэрээ байгуулах этгээдийг томилохыг зөвшөөрсөн 100%,
  - Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг баталсан 100% гэснийг уншиж танилцуулав.

Даргалагчаас: Тооллогын комиссын тогтоолыг сонслоо. Ингээд ХЭХ-аас тогтоол гарч байна. Тогтоол №01 утга:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Хавсралт №01-ээр, Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №02-оор тус тус баталж,
2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган хувьцаа эзэмшигчдээс гаргасан санал шүүмжлэл, санаачлагыг үйл ажиллагаандаа тусган зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалган,
3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгож,

Тогтоол №02 утга:

1. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, аудитын дүгнэлт гаргах байгууллагаар Монгол улсын "Мишээл Од" ХХК-ийг томилж,
2. "Мишээл Од Аудит" ХХК-тай гэрээ байгуулах эрхийг тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгоод,
3. Хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг хууль, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгож,

Тогтоол №03 утга:

1. "Материалимпэкс" ХК-ийн "Дүрэм"-ийг Хавсралтаар шинэчлэн баталж,
2. Шинэчлэн баталсан компанийн дүрмийг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс дагаж мөрдөн,
3. Энэхүү дүрмийг баталсантай холбогдуулан "Материалимпэкс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар баталсан компанийн дүрмийг хүчингүйд тооцож, хурлын дарга гарын үсэг зурсан тухай уншиж танилцуулав.

Ингээд хуралдаа ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Хурал хаахаас өмнө хэлэх санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэснээр хурал 12 цаг 40 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ЛХАГВАЧУЛУУН

ХУРЛЫН ДАРГА



Г.АЮУШМАА